



Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам
"Монголиан Файнэншл Партнерс ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
МФП-26/10-02 тоот хурлын тогтоолын Гуравдугаар хавсралт

КОМПАНИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү "Компанийн ил тод байдал тайлагналын журам" (цаашид "**Журам**" гэх)-ын зорилго нь "Монголиан Файнэншл Партнерс" ББСБ ХХК (цаашид "**Компани**" гэх)-ийн хөрөнгө оруулагч, харилцагчын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бүтээхэд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, тайлагнах, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг Компанийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон холбогдох хууль бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 1.3. Энэхүү журмаар компанийн нийтэд, тогтмол хүргэх мэдээллийн харилцааг зохицуулах бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, гарсан шийдвэр, бусад баримт материал, хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх харилцаа нь Компанийн тухай хууль, болон бусад дүрэм, журмаар зохицуулна.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1 Энэхүү журамд заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1 "**Мэдээллийг нийтэд хүргэх**" гэж компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг өөрийн компанийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэхийг;
 - 2.1.2 "**Нээлттэй мэдээлэл**" гэж ББСБ-ын үйл ажиллагааны хүрээнд боловсруулж, цуглуулж, ашиглаж буй нийтэд зориулагдсан. хувилах, хадгалах, дамжуулах, гарган өгөхөд тусгай шаардлага тавихгүй мөн Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд нийтэд ил болгосон мэдээллийг;
 - 2.1.3 "**Мэдээллийг ашиглах**" гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилца.
 - 2.1.4 "**Мэдээллийг боловсруулах**" гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэрийг;
 - 2.1.5 "**Мэдээлэл цуглуулах**" гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;
 - 2.1.6 "**Харилцагч**" гэж ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг авч байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг;
 - 2.1.7 "**тухай бүрт мэдээлэх**" гэж энэ журамд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг тухайн үйл явдал болсон даруй холбогдох журмын дагуу нийтэд мэдээлэхийг;
 - 2.1.8 "**цахим баримт бичиг**" гэж мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой мэдээллийг.
 - 2.1.9 "**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**" гэж Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасан этгээдийг;
 - 2.1.10 "**Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга**" гэж Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан этгээдийг;
 - 2.1.11 "**Дотоод мэдээлэл эзэмшигч**" гэж ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд, албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд, тэдгээрийн холбогдох этгээд;

ГУРАВ. МЭДЭЭЛЭЛИЙГ ИЛ ТОД НИЙТЛЭХ,



ТАЙЛАГНАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1 Компани нь мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлагнахдаа дараах үндсэн зарчмуудыг удирдлага болгоно. Үүнд:
 - 3.1.1 хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
 - 3.1.2 хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;
 - 3.1.3 мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх;
 - 3.1.4 мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх;
 - 3.1.5 нийтийн мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш байх;
 - 3.1.6 нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх;
 - 3.1.7 нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

- 4.1 Энэ журмын 4.2-т заасан мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулах үүргийг ТУЗ-аас үүрэг болгосон этгээд нь гүйцэтгэх бөгөөд мэдээллийн үнэн зөвийг компани хариуцна.
- 4.2 ТУЗ-аас үүрэг болгосон этгээд нь мэдээллийг нийтэд хүргэхдээ Компанийн цахим хуудсанд өөрөө байршуулна.
- 4.3 Компани энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан дотоод журам баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болно.
- 4.4 Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь компаниас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж гарсан үр дагаврыг хариуцна.
- 4.5 Компанийн цахим хуудсанд олон нийтэд мэдээлсэн мэдээллийг компанийн албан ёсны мэдээлэл гэж үзэх бөгөөд компани нь бусад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж болно.
- 4.6 ББСБ нь нээлттэй мэдээллийг ББСБ-ын албан ёсны веб хуудсанд байршуулж, олон нийтийг тухай бүр танилцах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

ТАВ. ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

- 5.1 Компани нь Компанийн тухай хууль болон энэ журамд заасан мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээллэх үүрэгтэй.
- 5.2 Компани нь энэ журмын 1.3-д заасан аливаа мэдээллийг Монгол хэлээр хүргэх ба уг мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан хүргэнэ. Компани нь шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг хүргэж болно.
- 5.3 Компанийн хугацаат тайлан нь хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна.
- 5.4 Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:
 - 5.4.1 Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл**
 - 5.4.1.1 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
 - 5.4.1.2 Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;
 - 5.4.1.3 Компанийн үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;
 - 5.4.1.4 Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
 - 5.4.1.5 Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан;
 - 5.4.1.6 Нийгмийн хариуцлагын тайлан;
 - 5.4.2 Удирдлагын талаарх мэдээлэл**
 - 5.4.2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
 - 5.4.2.2 Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулалын хэмжээ, тэдгээрийг эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;

- 5.4.2.3 ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан;
- 5.4.2.4 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
- 5.4.2.5 Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
- 5.4.2.6 Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулга, дүгнэлт

5.4.3 Бусад шаардлагатай мэдээлэл

- 5.4.3.3 Энэ журамд заасан тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл;
- 5.4.3.4 Компани шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

ЗУРГАА .ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

- 6.1 Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчид компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тухай бүр энэ журамд заасны дагуу нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 6.2 Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:
 - 6.2.1 Санхүүгийн мэдээлэл**
 - 6.2.1.1 Компанийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;
 - 6.2.1.2 Компани төлбөрийн чадваргүй болох;
 - 6.2.1.3 Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах;
 - 6.2.2 Санхүүгийн бус мэдээлэл**
 - 6.2.2.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
 - 6.2.2.2 Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;
 - 6.2.2.3 Компани үйл ажиллагаандаа шинэ техник технологи нэвтрүүлэх;
 - 6.2.2.4 Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулсан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, бараа, тэмдэг эзэмших болон цуцлагдах;
 - 6.2.2.5 Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа, салбар нэгж болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн;
 - 6.2.2.6 Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл;
 - 6.2.3 Удирдлагын талаарх мэдээлэл**
 - 6.2.3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр, хурлын зар болон хурлаас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт материал;
 - 6.2.3.2 Компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;
 - 6.2.3.3 Компани нь энэ журмын 5.2-т заасан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсоноос хойш ажлын 1 өдөрт багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХЭД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

- 7.1 Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг энэхүү журамд заасны дагуу нийтэд мэдээлэхээс өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 7.2 Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.
- 7.3 ТУЗ-аас үүрэг болгосон этгээд нь энэ журмын 5.4-т заасан эрхийг компанийн ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, ашиглуулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.
- 7.4 Компанийн цахим хуудсанд олон нийтэд мэдээлсэн мэдээллийг компанийн албан ёсны мэдээлэл гэж үзэх бөгөөд компани нь бусад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж болно.

НАЙМ. ХАРИУЦЛАГА



- 8.1 Энэхүү журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй бол Компани нь холбогдох хууль, хяналтын байгууллагад хандаж шалгуулна.
- 8.2 Энэхүү журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүйд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран Компани нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.
- 8.3 Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь Компанийн нэр хүндэд гэм хор учруулсан бол уг гэм хорыг гэм буруутай ажилтан бүрэн хариуцна.

---oOo---